

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ 2022 ОНД
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 01 сарын 12

Өргөн

Д/д	Заалт	Арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрэх түвшин, үр дүн	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1		1.1. Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг хийж, төрийн үйлчилгээг сайжруулах.		Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнгээр сахиулах хариуцлагыг сайжруулж төрийн үйлчилгээг шуурхай болгосон байна.	Иргэдээс төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэлийг хийсэн. Хавсралт : 1 файл	100%
2	1. Төрийн захиргаа, удирдлага зохион байгуулалт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд:	1.2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах.		Засгийн газрын бодлого шийдвэрийг сум орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.	Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналтад авсан заалтын тоо: 7 хэрэгжилтийг хяналтанд авч хэрэгжилтийн тайлагнаж ажилласан. Хэрэгжилтийн дундаж хувь 72.8% Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан заалтын тоо: 83 хэрэгжилтийг хяналтанд авч хэрэгжилтийн тайлагнаж ажиллаж байна.	90%
3		1.3. Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, үр дүнг тооцож тайлагнах.		Орон нутаг хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний үр дүн	Аймгийн таван жилийн үндсэн чиглэлийн хяналтад авсан заалтын тоо:82 заалтыг хэрэгжилтэнд авсан. Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналтад авсан заалтын тоо: 30 хэрэгжилтийг хяналтанд авч, тайлагнаж ажилласан. 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хяналтад авсан заалтын тоо:11 хэрэгжилт хяналтанд авч, тайлагнаж ажилласан.	90%
4		1.4. Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, тайлагнах .		Орон нутаг хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний үр дүн	Аймгийн ИТХ-ын тогтоолын хяналтан авсан заалтын тоо-8 Захирамжийн хяналтад авсан заалтын тоо-116 Албан даалгаврын хяналтад авсан заалтын тоо-64 хяналтанд авсан байна.	90%

1	3	4	5	6	7
5	1.5. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх.		Албан хаагчдын ажиллах нөхцөл, сурч хөгжих боломж бүрдэж, хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг сумын хэмжээнд боровсруулан батлаж түүний дагуу төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт 90 дээш хувийн биелэлттэй явж байна.	100%
6	1.6. Төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий бүх шатны байгууллага, ажиллагсадтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллах.		Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна. Албан хаагчдын үүрэг хариуцлага сайжирсан байдал.	Төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий бүх шатны байгууллага, ажиллагсадтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж хагас бүтэн жилээр дүгнэн хариуцлага тооцох, урамшуулах ажил хэвшсэн. Санал асуулгын жилд 2 удаа авдаг. Хариуцлага тооцсон албан хаагч одоогоор байгүй байна.	100%
7	1.7. Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулан ажиллах.		Төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн ажилласан байна.	Аймгийн төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс зохион байгуулж байгаа "Ёс зүйтэй төрийн алба-2" аянд нэгдэж төлөвлөгөө гарган биелэлийн ханган оролцож, байгууллагын нийт 28 ажилтнаас 16 албан сургалт зохион байгуулж, сургалттай холбогдуулан уралдаан зохион байгуулсан. Одоогоор ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. Хавсралт : 4 зураг	100%
8	1.8. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг сумын хэмжээнд зохион байгуулж, төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулалтгүйгээр томилохгүй байх.		Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг сумын хэмжээнд зохион байгуулж, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулалт явуулан томилон ажиллаж байна.	100%

1	3	4	5	6	7
9	1.9. Сумын төрийн байгууллагуудын дотоод, гадаад үйл ажиллагааг хяналт, удирдлагын нэгдсэн “ERP” системээр явуулж, мэргэжилтэн ажилтан бүр ашиглалтыг сайжруулах, удирдлага хяналт тавих.		Байгууллагын дотоод үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, • Удирдлагын хяналт, • Хүний нөөцийн мэдээлэл, • Ажил төлөвлөлт, • Үүрэг даалгавар, • Хурал, • Ажлын хэсэг, • Өргөдөл гомдол, • Албан бичиг, харилцаа, • Цаг бүртгэл, • Тайлан, • Судалгаа “ERP” систем ашиглан өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулж хэвшсэн байна.	Сумын төрийн байгууллагуудын дотоод, гадаад үйл ажиллагааг хяналт, удирдлагын нэгдсэн “ERP” системээр явуулж, мэргэжилтэн ажилтан бүрт ашиглалтыг сайжруулах талаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	90%
10	1.10. Сумдын албан ёсны цахим хуудасны ашиглалтыг нэмэгдүүлж, өдөр тутмын мэдээ мэдээллийг нийтэлж сумын “Ил тод байдал”-ын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллах.		Иргэдийг цахим орчинд мэдээ мэдээллээр хангаж, сумын ил тод байдлыг нэмэгдүүлсэн байна.	Сумын вэб хуудасны ашиглалтыг бүрэн сайжруулж шаардлагатай 46 мэдээлэл болон нэмэлт мэдээлэлүүдийг бүрэн оруулсан. Хавсралт : 1 файл	100%
11	1.11. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, орон нутгийн хөгжил, нийгэм эдийн засгийн байдлын талаар иргэд олон нийтэд сурталчлах, ил тод нээлттэй, мэдээлэх, “Өнөөгийн Баянхонгор” сониныг захиалах.		Баянхонгор аймгийн албан ёсны цахим сайтад бүх сумдын мэдээллийн сан бүрдэж, төрийн үйл ажиллагааны нэгдсэн тоо баримт бүхий бодит мэдээ мэдээллийг нэг цонхоор хүргэсэн байна.	2022 онд Өнөөгийн Баянхонгор сонинг захиалаагүй болно. Мөн сумын вэбсайтуудаар мэдээллийг тогтмол түргэн шуурхай хүргэж ажиллаж байна.	100%
12	1.12. Сумын цахим мэдээллийн самбар буюу Dashboard-нд өдөр сар улирал, хагас жилээр гардаг тоон мэдээллийг үнэн зөв оруулж хэвших.		Иргэд, ААН сумын хэмжээний тоон мэдээлэл, өдөр тутмын үйл ажиллагааны талаар цахимаар мэдээлэл авах боломж бүрдсэн байна.	Сумын цахим мэдээллийн самбар буюу Dashboard-нд өдөр сар улирал, хагас жилээр гардаг тоон мэдээллийг үнэн зөв оруулж хэвших.	100%

1	3	4	5	6	7
13	1.13. Тоон гарын үсэг ашиглаж цаасны хэрэглээг багасгах.		Цаасгүй технологийг нэмэгдүүлж, байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн системд тоон гарын үсэг ашиглаж хэвшсэн байна.	Тоон гарын үсгийг 575 иргэнд, мобайл ард 72 иргэнд олгоод байна. Утасны мобайл апп-г ашиглаж иргэд өөрт хэрэгтэй мэдээлэл мөн лавлагаа үйлчилгээг ямар ч чирэгдэлгүйгээр авах нөхцөл боломжоор ханган ажиллаж байна. Сумын хэмжээнд тоон гарын үсгийн олголт 35% тай байна.	70%
14	1.14. Байгууллагуудын интернет сүлжээний хурдыг нэмэгдүүлж, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах, мэргэжилтэн ажилтнуудын мэдлэгийг сайжруулах.		Цахим шилжилт, цахим засаглалын хүрээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд техникийн болон хүний нөөцийн мэдлэг, ажиллах нөхцөл сайжирсан байна.	Байгууллагуудын интернет сүлжээний хурдыг нэмэгдүүлж, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах, мэргэжилтэн ажилтнуудын мэдлэгийг сайжруулан үйл ажиллагаагаа явуулж байна.	100%
15	1.15. Гадаад бодлогыг хэрэгжүүлэхдээ харьяалах нутгийн захиргааны байгууллагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу чанартай зохион байгуулах.		Сум орон нутагт гадаад бодлого хамтын ажиллагаа үр дүнтэй зохион байгуулагдсан байна.	харъяалах нутгийн захиргааны байгууллагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу зохион байгуулдаг.	100%
16	1.16. Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийг сум орон нутагт амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэх.	5.8 сая	Төсөл хөтөлбөрийн үр дүнд өгөөж нэмэгдсэн байна.	Дэлхийн зөн БХР-2 ОНХ-өөс зарласан “Зөвлөгөө өгөх өрөө” тохижуулах санхүүжилт олгох төслийн уралдаанд Хамтарсан багаас оролцсон төсөл шалгарч 5,8 сая төгрөгний санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Төслийн хүрээнд ЗДТГ-аас нэг өрөөг гаргаж тохижилтийг хийж, үйл ажиллагааг эхлүүлээд байна. энэхүү өрөөгөөр Сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудалхариуцсан мэргэжилтэн, Жрүүл мэндийн нийгмийн ажилтан, Боловсролын нийгмийн ажилтан нар тус тус мэргэжлийн чиглэлийн анхан шатны зөвөлгөөг хүүхэд гэр бүлд өгөх юм. Нийт төсөв 5,8 сая Шалгуур: шинээр зөвлөгөө өгөх өрөөтэй болох	100%
17	2.1. Аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр сум орон нутагт шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах		Сум орон нутагт цаг үеийн арга хэмжээг хурдан шуурхай үр дүнтэй зохион байгуулсан байна.	хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж байна.	100%

1	2	3	4	5	6	7
18	2. Гамшгийн үеийн бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд: 3. Хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд:	2.2. Сумын Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагааг 24 цагийн горимоор ажиллуулж үйл ажиллагааг эрчимжүүлэх албан тушаалтнуудыг үүрэгжүүлэх.		Шуурхай штабын бэлэн байдал хангагдсан байна.	шаардлагатай үед сумын онцгой комиссыг 24 цагаар ажиллуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.	100%
19		2.3. Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хагас бүтэн жилээр тодотгол хийж, хэрэгжилтийг хангах.		Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний мэдээлэл шинэчлэгдсэн байна.	Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хагас бүтэн жилээр тодотгол хийгдсэн.	100%
20		2.4. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эм эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцасны нөөцийг орон нутгийн түвшинд бүрдүүлэх.		Хамгаалах хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлсэн байна.	нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.	100%
21		2.5. Гамшгаас эрсдэлээс урьдчилан сэргийлэх замаар Сумын Засаг даргын нөөц хөрөнгийн санг нэмэгдүүлэх.		Гамшгийн нөөц хөрөнгийг бүрдүүлсэн байна.	нөөц хөрөнгийн санг нэмэгдүүлэн ажиллаж байна.	100%
22		2.6. Мал амьтны шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хамгаалах, хорио цээрээр хязгаарлалтын дэглэмийг чанд мөрдөж ажиллах, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах		Хорио цээрийн хязгаарлалтын дэглэмийг чанд мөрдөж ажилласан байна. Иргэд малчдын, хүн мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилсэн байна	Хүн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг сумын хэмжээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж урьдчилан сэргийлэх гарын авлага брошур тарааж ажилласан.	100%
23		2.7. Сумын сайн дурын бүлгийг томилгоожуулж үйл ажиллагааг жигдрүүлэх.		Сум тус бүр гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг байгуулагдаж гамшиг ослын үед үүрэг гүйцэтгэх хүн хүч нэмэгдсэн байна	Бүлгийн үйл ажиллагаа тогтмол явагдаж байна.	100%

1	3	4	5	6	7
24	2.8. Гамшиг осол, аюулт үзэгдэл гал түймэр, хүн мал амьтны гоц халдварт өвчний үед ажиллах гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангах.		Сумын гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангасан байна.	2022 онд Гамшиг осол, аюулт үзэгдэл гал түймэрийн дуудлага гараагүй. Хүн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг сумын хэмжээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж урьдчилан сэргийлэх гарын авлага брошур тарааж ажилласан.	100%
25	3.1. “Зөв амьдрал” хөтөлбөрийг хэрэгжүүлж, архины хамаарал бүхий иргэдийг эмчилгээнд хамруулж, ажлын байраар хангах.		10 иргэн татгалзаж, 5 иргэн тогтмол хөдөлмөр эрхлэсэн байна. Шалтгаант гэмт хэрэг өмнөх оноос нэг нэгжээр буурсан байна	Архи согтууруулах ундаа хэрэглэдэг баг насны хүүхэд бүртгэгдээгүй. Бага насны хүүхэд архи согтууруулах ундаа хэрглэсэн, гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй. Баянговь сум Жаргалтай амьдрал төвтэй хамтран ажиллаж 9 удаагийн анхан болон давтан эмчилгээгээр 46 иргэнийг архинаас гаргах болон донтолтын тусламж үйлчилгээ үзүүлсэн.	100%
26	3. Хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд: 4. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулж, боловсролын чанарын үзүүлэлтийг сайжруулах хүрээнд:	3.2. Цагдаагийн хэсгийн төлөөлөгтэй гэрээ байгуулж гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.	Гэрээ байгуулж хагас бүтэн жилээр дүгнэсэн байна. Сумын хэмжээнд гэмт хэргийн тоо буурсан байна	Баянхонгор аймгийн цагдаагийн газраас зохион байгуулагдаж буй нэгдлсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол ажил зохион байгуулж, тодорхой гэмт хэрэг зөрчлийг бууруулах чиглэлээр нийт 17 төрлийн ажил зохион байгуулагдаж хулгайлах, хүний бие махбодийн эсрэг халдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэн тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллалаа.	90%
27	3.3. Авлигын эсрэг, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцох .		Тоо: Хамрагдсан иргэдийн тоо Чанар:Гарсан үр дүн	Авлигын эсрэг, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн. Сургалтанд хамрагдсан хүний тоо-700 Хавсралт : 1 файл	100%
28	3.4. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцох .		Иргэдийн эрх зүйн боловсрол дээшилсэн байна.	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор ард иргэд малчдад хууль эрх зүйн гарын авлага 10600 ширхэгийг тараасан.Хууль эрх зүйн талаар сургалтыг сумын хамтарсан баг болон эрүүл мэндийн төвтэй хамтран 3 удаагийн сургалт явуулсан. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Баянхонгор аймгийн Хүүхэд гэрбүл залуучуудын хөгжлийн газрын алба хаагчилтай хамтран “Хамтдаа шийдье” арга хэмээг зохион байгуулж Баянговь сумын малчдад 1–5 дугаар багт 5 ажлын хэсэг гарч ажиллан 300 орчим өрхүүдээр орж сургалт зохион байгуулсан. Хууль эрх зүйн талаар сургалтыг сумын ГХЗУСАЗСЗ-с Жаргалтай амьдрал төвтэй хамтран 6 байгууллагад 6 удаагийн сургалт явуулсан.	90%

1	3	4	5	6	7
29	3.5. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” аймгийн дэд хөтөлбөрийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллаж, Орон нутгийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой бодитой ажлыг зохион байгуулах.		Гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан байна.	Баянговь сумын хамтарсан багаас гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр танхимаар 6 сургалт, цахимаар 4 сургалт тус тус явуулсан. Сургалтанд нийт давхардсан тоогоор 400 иргэд хамрагдсан. Гэр бүлийн боловсролын талаарх мэдээлэл, шторк бичлэгийг Баянговь сумын мэдээ мэдээлэл веб хуудсанд байнга байршуулж байна. Аймгийн ГБХЗХ-ын газар сумын хамтарсан багтай хамтран 5 багийн 0-17 насны хүүхэдтэй 600 гаруй өрхүүдээр орж “Бага насны хүүхдийн асаргаа” “Хүүхдийн аюулгүй байдал” “Хүүхдийн насны онцлог”-ын талаар мэдээллийг хүргэж ажилласан. Энэхүү үйл ажиллагаанд нийт 20 албан хаагч 5 ажлын хэсэгт хуваагдан ажилласан ба шатахууны зардлыг Сумын ЗД-ын нөөц хөрөнгөөс 500,000 төгрөгний шатахууныг зарцуулсан. нийт 800ш гарын авлага бэлтгэн хүргүүлсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 3 хэрэг бүртгэгдээгүй байна. 14 дуудлага мэдээлэл дээр кейс нээж ажиллаж байна. Аймгийн ГБХЗХ-ын газар сумын хамтарсан багтай хамтран 5 багийн 0-17 насны хүүхэдтэй 600 гаруй өрхүүдээр орж “Бага насны хүүхдийн асаргаа” “Хүүхдийн аюулгүй байдал” “Хүүхдийн насны онцлог”-ын талаар мэдээллийг хүргэж ажилласан.	100%
30	3.6. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, баримтын бүрдүүлэлт, шийдвэрлэлтийг шинэ шатанд гаргах.		Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, баримтын бүрдүүлэлт, шийдвэрлэлтийг шинэ шатанд гаргах	Сургууль: Байгууллагаас гарч буй баримтыг архив, албан хэрэг хөтлөлтийн заавар журмын дагуу БНШК-оор хянуулан байгууллагын архивт жил бүр нөхөн бүрдүүлэлт хийж ирсэн. Тухайн 2021, 2022 ондуудын баримтыг байгууллагын архивт хүлээн авч, төрийн архивын төлөвлөгөөт хуваарийн дагуу 2020 оны байнга хадгалах баримтад нөхөн бүрдүүлэлт хийлээ.	90%
31	3.7. Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд нийт ажилтнууд 16 цагийн сургалтад хамрагдах.		Төрийн албан хаагчдын мэдлэг, чадвар дээшилсэн байна.	Тус сургуулийн албан хаагчдад шинээр мөрдөж буй албан хэрэг хөтлөлтийн стандартаар ганцаарчилсан зөвлөгөөг өгч ажилласан. Нийт 29 албан хаагчдад өгсөн.	70%

1	3	4	5	6	7
32	3.8. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хүрээнд Төрийн архивын үндсэн санд 2019 оны байнга хадгалах болон 2020 оны мал тооллогын баримтыг тус тус цаасаар болон цахим хувь, дансны хамт шилжүүлэх.		Байгууллагын баримтыг бүрэн шилжүүлсэн байна.	Сургууль: Архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын болон төрийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх ажлыг ажлын төлөвлөгөөний дагуу байгууллагын баримт нягтлан шалгах комисс 2019 оны цаасан суурьтай 74 баримтыг эмхлэн цэгцэлж цахимаар өгөх бэлтгэл ажлыг хангаж, баримтыг эрэмбэлэж цахим хэлбэрээр программд заавар журмын дагуу шивж орууллаа. Уг баримтыг төрийн архивт шилжүүлэхдээ нэгдүгээр үдэлт буюу нэг хадгаламжийн нэгж баримтыг цагаан цаасаар (хамгаалалтын хуудас) үдэж, хоёрдугаар үдэлтийг бор кордоноор үдэж сум хариуцсан болон программ хангамж сүлжээ иж бүрэн нягтлан шалгалт хариуцсан ажилтан болон, Төрийн архивын тасгийн дарга В.Эрдэнэчимэг нараар цаасан баримтаа хянуулан цаасан баримтыг хамгаалалтын хайрцаганд хийж 3% үйлдэн аймгийн Төрийн архивын тасгийн цахим санд нөхөн бүрдүүлэлт хийлээ. Цахимд агуулга, газар зүйн нэр, хүний нэр, байгууллагын нэр гэсэн өгөгдөл шивж jpg өргөтгөлөөс pdf өргөтгөлд хөрвүүлж өгөгдөл болон багцаар Төрийн архивын www.e-document.gov.mn системд холбон Төрийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлэн Төрийн архивт шилжүүлэн хүлээлгэн өглөө.	100%
33	3.9. “Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах.		Байгууллага бүр архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулсан байна.	Байгууллагын архив нь сургууль дотроо 1.5 х 3.3 м2 талбайтай тусгай өрөөтэй бөгөөд дулаан, чийг хэмжигчтэй. Мөн бичиг хэргийн 1ш сейфтэй бөгөөд уг сейфэд тамга тэмдэг болон албан хэвлэмэл хуудас хадгалагддаг. Архивт хадгалагдаж байгаа баримтыг бор кордоноор үдэж 100% хамгаалалтын хайрцагт хийж, тавиурт байршуулсан.	90%
34	3.10. Байгууллагын тусгай төрлийн /гэрэл зураг, дуу дүрсний/ 2021 оны баримтыг Төрийн архивт шилжүүлэх.		Баримтыг архивт шилжүүлсэн байна.	Байгууллагын 2021 оны тусгай төрлийн баримтыг төрийн архивт шилжүүлсэн.	90%
35	4.1. Орон нутагт боловсролын тулгамдаж буй асуудлыг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн, гарсан санал санаачлагыг бүрэн хэрэгжүүлэх.		Тулгамдсан асуудал шийдвэрлэсэн байна.	гарсан санал байхгүй болно.	90%

1	2	3	4	5	6	7
36	4. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулж, боловсролын чанарын үзүүлэлтийг сайжруулах хүрээнд: 5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, амьдрах бүрдүүлэх, нийгмийн мэндийн чиглэлээр:	4.2. Таван настнуудыг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулах, малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих.		Таван настнуудыг бүрэн хамруулж, сургуулийн өмнөх боловсрол олгож, сургуульд бэлтгэсэн байна.	2022-2023 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн суралцагчдыг СӨБ-ын үйлчилгээнд бүрэн хамруулсан 2022 – 2023 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид орох хамран сургах тойргийн 6 – 15 насны нийт 67 хүүхдээс 1 хүүхэд ирэх жил орохоор өнжиж, 9 хүүхэд өөр аймаг сумд суусан ба тойргийн бус 8 хүүхэд бүртгүүлж нийт 65 хүүхэд сургуульд орсон. Нэгдүгээр ангийн орох хүүхдийн системийн бүртгэлийг сургалтын менежер, БЗАН-ийн ахлагч нар эцэг эхчүүдтэй холбоо барьж хугацаанд нь 100% бүртгүүлсэн. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг сургалтын менежерээр ахлуулсан бага ангийн 2 багш, хөгжим, биеийн тамирын багш, цэцэрлэгийн арга зүйч нар заавар зөвлөмжийн дагуу хийсэн. Энд 1 дүгээр ангийн нийт 65 хүүхэд эцэг эхийн хамт хамрагдсан.	100%
37	хүртээмжийг сайжруулж, амьдрах бүрдүүлэх, нийгмийн мэндийн чиглэлээр:	4.3. Сургуулийн дотуур байрны орчны эрсдэлийн үнэлгээг хийж, хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт нөлөөллийн ажлыг үе шаттай.		Хүүхэд хамгааллыг сайжруулсан байна.	Дотуур байрын гадна, дотор орчны эрсдэлийн үнэлгээг хийж үнэлгээний багаас гарсан зөрчилтэй байгаа саналыг нэгтгэж зохих газарт хүргүүлсэн. Мөн дотооддоо байрны багшаар ахлуулсан ажлын хэсэг дотуур байрны гадна, дотор орчны эрсдэлийн үнэлгээ хийсэн ба зөрчилтэй байсан тог цахилгааны ил гарсан утсыг далдалж, гадна орчинд байсан төмөр гадас, 9ш төмөр утас гарсан хугархай хавтангуудыг ачиж холдуусан. Мөн сургуулийн гадна, дотно аюулгүй орчны эрсдэлийн үнэлгээг хийж холбогдох газар хүргүүлсэн. Дотуур байрын орчинд Сурагчдыг тог цахилгаанд цохиулах, гал гарах аюулаас сэргийлж ил болон далд цахилгаан утас, унтраагуур зэрэгт байнгын үзлэг шалгалт хийдэг. Мөн цахилгааны шийд цоожтой байдаг бөгөөд хариуцсан өдрийн жижүүрүүд тогийг нээж хаадаг. Сурагчдын гар утсыг цэнэглэхдээ нэгдсэн байдлаар хураан авч байрны багш болон жижүүрийн хяналтад цэнэглэдэг. Мөн дотуур байрны хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг хэрэгжүүлэх, хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах, хүсэл сонирхол, санаа бодлыг нэгтгэх, шийдвэрлэх түвшинд дуу хоолойг хүргэх зорилгоор “Хүүхдээ сонсох өдөр” үйл ажиллагааг 10 дугаар сарын 25-нд зохион байгуулан явууллаа. Үйл ажиллагаанд сургуулийн хүүхдийн элч Өнөрчимэг, байрны эцэг эхийн зөвлөлийн дарга Амарбаяр, сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн Мөнхтогтох, сургуулийн нийгмийн ажилтан Базаррагчаа, багш нар, дотуур байрны ажилчид болон дотуур байрны нийт 82 сурагч оролцсон. “Хүүдээ сонсох өдөр”-т сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн Б.Мөнхтогтох “Сурагчийн үүрэг”, сургуулийн нийгмийн ажилтан Б.Базаррагчаа “Сурагчдын үе тэнгийн дарамт” сэдэвт сургалт мэдээлэл өгсөн.	100%

1	3	4	5	6	7
38	4.4. Хэлний бодлогын сумын салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлж, төрийн албан хаагчдын болон иргэдийн “Монгол бичиг”-ийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх.		Төрийн албан хаагчдын монгол бичгийн ур чадвар дээшилж, төрийн албыг монгол бичгээр хослон эрхлэх бэлтгэлийг хангасан байна.	ЕБС-Өнгөрсөн жил байгууллага бүр дээр мэргэжлийн багш нар үндэсний бичгийн хичээлийг зааж сургагч багш бэлтгэж одоо бэлтгэсэн сургагч багш нар байгууллагынхаа албан хаагч бүрт сургалтыг үргэлжлүүлэн мэргэжлийн багш нараас зөвлөгөө авч явуулж байна. Жинст сумын НТБН-менежер С.Оюунбилэг багштай хамтран "Бийрийн бичгийн 5 өдрийн сургалтаа 2022 оны 11 дүгээр сарын 05-наас 09-ны хооронд амжилттай зохион байгууллаа. Өглөөний 8 цагаас оройн 20 цаг хүртэл бүтэн 4 өдөр хичээллээд 5дахь өдөр бүтээлээрээ бүтээлийн үзэсгэлэн гаргалаа. Нийт 19 сурагч 6 багш хамрагдсан. Төрийн албан хаагч иргэдийн дунд “Үндэсний бичгээрээ нэрээ зөв бичигчээ” цахим #challenge- д нэгдэж иргэд албан хаагчид нэгдэж монгол бичгээр нэрээ бичиж давалгаалсан нь иргэдийн сонирхолыг татаж иргэдээс мөн оролцсон.	100%
39	4.5. Цэцэрлэг, сургуулийн сурагчдын эрүүл ахуйн стандартыг хангуулах, сургууль, цэцэрлэгийн орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх, багш ажилтнууд болон сурагчдын гар угаах, ариун цэврийн орчныг сайжруулах, саван ариутгалын бодисын хангамжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих.		Сургууль цэцэрлэгийн орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт сайжирч халдвар өвчний гаралт буурсан байна. Иргэд, аж ахуй нэгжээс ирсэн хандивын хэмжээ Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, багаж хэрэгслийн хангамж нэмэгдсэн байна	Байгууллагын гадна дотно орчинд халдваргүйжүүлэлтийг сар бүр хийснээр халдварт өвчлөл гараагүй. Сургуулийн сурагчдыг сурч боловсроход эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлж цэвэрлэгээг хуваарийн дагуу өдөрт 2-3 удаа хийж халдваргүйжүүлэлтийг цэвэрлэгээний дараа тогтмол хийж, ариутгалыг 14 хоногт нэг удаа хийж байна. Багш, ажилчдын болон сурагчдын гар угаах, ариун цэврийн орчныг бүрдүүлсэн. Сургуулийн био 00 2019 онд, дотуур байрын био 00 2021 онд ашиглалтанд орсон.	100%
40	4.6. Багш, ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах.		Багш нарын нийгмийн баталгааг хангахад ахиц гарсан байна.	Эрүүл мэндийн багц үзлэг шинжилгээнд 14 багш ажилчдыг хамруулсан. Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчдын эрүүл мэндийн үзлэгт бага ангийн 10 багш, дотуур байрын 1 багш , дунд ангийн 14 багш болон 3 тогооч, захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, нярав зэрэг хүмүүс хамрагдсан. с	100%

1	3	4	5	6	7
41	4.7. Багш, нарын мэдээлэл холбооны технологи ашиглах чадвар, цахим контент бэлтгэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дээрээ хөгжих орчныг бүрдүүлэх, "Багш хөгжлийн төв" -д дэмжлэг үзүүлэх;		"Багш хөгжлийн төв" –ийн үйл ажиллагаа өргөжиж байр удирдах ажилтны ажлын байран дээрх мэргэжил, ур чадвар сайжирсан байна	Багш, нарыг мэдээлэл холбооны технологи ашиглах чадварыг сайжруулж ажлын байранд сургалт зохион байгуулан багш нар 18 цахим хичээлийг бэлтгэн сургалтад ашиглаж байна. Багш нарын ажиллах нөхцлийг сайжруулж "Багш хөгжлийн төв"-д өнгөт хэвлэгч, УИХ-ын дарга Занданшатарын дэмжлэгээр 2 багшийг зөөврийн компьютертэй болголоо. Мэдээлэл зүйн 1, бага ангийн 1 багш ЭХЦК боловсруулах арга зүйн сургалтад 2 удаа хамрагдан зөвлөгөө авч улмаар бага ангийн Эрүүл мэндийн хичээлээр ээлжит хичээлийн цахим контент бэлтгэсэн. Мөн физикийн 2 хичээлээр цахим контент хичээл бэлдэн medlee.mn сайтад байршуулсан. 12 багшийг Notebook -ээр хангасан.	100%
42	4.8. Ковидын дараах сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах.		Хүүхдийн сурлагын хоцрогдлыг нөхөж, бага суурь боловсролын стандартыг хангасан байна.	Энэ хичээлийн жилийн ТТШ-ыг 11 сард зохион байгуулсан бага анги 52,3%, дунд анги 42,8%-ийн гүйцэтгэлтэй тус тус шалгагдсан. Бага ангийн уншихын дундаж үг 56. Дээд уншлага 2-р анги 89 үг, 3-р анги 114 үг, 4-р анги 167 үг, 5-р анги 182 үг байна.	100%
43	4.9. Сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх, тухайн орон нутгийн хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, тохирлын баталгаанд хамруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах.		Сургуулийн хоол үйлдвэрлэлийн ажиллагаанд ахиц гарч, хүнсний аюулгүй байдал хангагдсан байна.	Үдийн хоолонд нийт 5 өдөрт ногоотой шөл, гоймонтой шөл, гоймонтой хуурга, пирошки, мантуун бууз, жигнэсэн мах, будаатай хуурга, кембаб гэх мэт 10 гаруй төрлийн хоол, луувангийн салат, алим луувангийн салат, жимсний салат, жигнэсэн алим зэрэг 8 төрлийн зууш салат, 3 төрлийн нарийн боов болон халуун аарц, чацаргана, хярам зэрэг уух зүйлсээр үйлчилдэг. Сумын талх нарийн боовны цехтэй хамтарч ажиллаж байна.	100%
44	4.10. Иргэдэд нөхөн боловсрол олгож, ерөнхий түвшнийг дээшлүүлж, өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх.		Иргэдийн амьдрах чадвар нэмэгдсэн байна	Энэ хичээлийн боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрт нийт 14 суралцагч суралцаж байна. Бичиг үсгийн боловсролын судалгааг гаргаж баг тус бүрээс бичиг үсэг үл мэдэшч 2 иргэнийг сураглатад хамруулахаар багийн дарга нартай ярилцаж нэрсийг гарган ажилласан. Эхний ээлжинд 14 хонгийн хугацаатай хичээллээд дараа нь бие даан суралцах материал хүргүүлэхээр болсон. НТБН-ээс нийт 14 төрлийн сургалтыг давхардсан тоогоор 1731 суралцагч, иргэдэд явуулсан байна. Өрхийн хөгжил: Баг бүрээс 2 өрх нийт 10 өрхийг багийн дарга, эмч нийгмийн ажилтангуудтай хамтран эхний суурь судалгааг авч цаашид хийх хөгжлийн төлөвлөгөөгөө гаргасан. СНБА, ЭСНА ЭХАБ-тэй хамтран нийт өрхүүдийн дунд багц сургалт, эрүүл мэндийн үзлэг тандалт судалгааг авч ажиллаа. Цайны зардлын ЗДТГ шийдэж амжилттай зохион байгуулсан.	100%

1		3	4	5	6	7
45		5.1. Иргэн бүрийг хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх.		Хүн амын 80-аас дээш хувийг хамруулсан байна.	Умай хүзүү, хөхний хавдарын эрт илрүүлэх үзлэгт 178 эмэгтэй хамрагдахаас 162 эмэгтэй хамрагдаж, 91%-тай байна. Хөхний хавдар умай хүзүүний өөрчлөлт илрээгүй байна. БЗДХ-ДОХ, Тэмбүү өвчин илрүүлэх хурдавчилсан оношлуурын шинжилгээг 266 хүнд хийхэд Тэмбүүгийн 6 өөрчлөлт илэрсэнийг ийлдс авч дээд шатлалд онош баталгаажуулахад 1 батлагдаж, 5 шинжилгээний хариу хүлээгдэж байна. Чихрийн шижин хэв шинж 2 хамрагдвал зохих зорилтот насны 1009 хүнээс 782 хүн хамрагдаж 77,5%-тай, өөрчлөлтэй 2 хүн батлагдсан. Артерийн даралт ихсэх өвчний эртилрүүлэгийн үзлэгт хамрагдвал зохих зорилтот насны 1526 хүнээс 1169 хүн хамрагдаж 76,6% -тай байна.	100%
46	5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: 6. Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:	5.2. Сургууль цэцэрлэгийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн чанар хүртээмжийг сайжруулан (“үдийн хоол”, “эрүүл шүд”) хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоог хангах.		Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалсан байна.	СӨБ, ЕБС-ийн нийт 992/давхардсан тоогоор/ хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс шүд цооролттой 293 /давхардсан тоогоор/ хүүхэд байснаас 76 хүүхдийн шүдийг шүдний эмчтэй хамтран эрүүлжүүлж эмчилсэн. Хоолойны өвчлөлтэй 85/давхардсан тоогоор/ хүүхэд байсан. Үүнээс шүдний цооролттой 46 хүүхдийг шүдний эмчтэй хамтран эрүүлжүүлсэн. Гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй 5 хүүхдийг дээд шатлалын эмнэлэгт илгээсэн. Гүйлсэн булчирхай томролттой 63 хүүхдэд эм бичиж, эцэг эхчүүд, багш нарт дулаан хувцаслах, даарч хөрөхгүй байх, чанартай хоол унд, витаминжуулах тал дээр зөвлөгөө өгч гарын авлага тараасан. Мөн харааны өөрчлөлттэй 18 хүүхдийг нүдний нарийн мэргэжлийн эмчид үзүүлж, хараа шалгуулж, эмчлүүлэх зөвлөгөө өгсөн. Арьс харшилийн өөрчлөлттэй 5 хүүхдэд эм бичиж өгсөн. Фимозтой 5 хүүхдэд эрүүл ахуйн зөвлөгөө өгч цаашдаа нарийн мэргэжлийн эмчид үзүүлэхийг зөвлөсөн.	100%
47		5.3. Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулах.		Өмнөх оноос 0.5 хувиар буурсан байна.	Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлтийг тогтмол чанартай хийсэнээр 2022 онд эх болон 0-5 насны хүүхдийн эндэгдлийг ажилласан. Золгүй тохиолдлоор 3 сартай 1 хүүхэд эндсэн.	100%

1	3	4	5	6	7
48	5.4. Алслагдсан багийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г сумандаа зохион байгуулах.		“Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г алслагдсан багуудад хүргэж, эрүүл мэндийн чанарын үзүүлэлтийг сайжруулсан байна.	2022 оны 04 сарын 11-18 –ны хооронд сумын 5 багуудаар гойрч алслагдсан нутагт оршин сууж байгаа нийт 496 иргэдэд дурьдчилан сэргийлэх үзлэг хийж, эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Даралт, Элэгний В, С, Дох, Тэмбүүгийн шинжилгээ авсан. Мөн 2022 оны 10 сарын 25 – 30 –ны хооронд 5 багийн хурал дээр очиж үзлэг шинжилгээ хийсэн. Нийт 282 малчин хамрагдсан байна. Хавсралт : 8 зураг	100%
49	5.5. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан залуусын эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.		Эрүүл мэндийн даатгалын хамралтыг өмнөх оноос нэмэгдүүлсэн байна.	Амбултороор үйлчлүүлж байгаа нийт иргэдэд эрүүл мэндийн даатгалд хамрагдахын ач холбогдолыг талаар мэдээлэл хүргэж ажиллаж байна. Нийт 469 иргэнд мэдээлэл хүргэсэн.	100%
50	6.1. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх.		Байнгын ажлын байраар 15-20, түр ажлын байраар 100-150 иргэнийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ	Жилийн эцсийн байдлаар байнгын ажлын байр 23 гарсан ба улирлын чанартай ажил 18, түр ажлын байр 68 гарав. Мөн Халамжаас-хөдөлмөрт хөтөлбөрийн зорилтыг хангах ажлын хүрээнд мөн сум үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн ажлын хүрээнд хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдийг нийтийг хамарсан ажил болох хог цэвэрлэгээ, хашаа хороо, гудамж тохижуулах, ногооны талбайд мод тариалах, наадам парк дээр мод тариалах зэрэг ажилд татан оролцуулсан. Мөн зорилтот бүлгийн өрхийн гишүүдийг туслах төлчин, ямаа самналт зэрэг ажлуудад зуучлан ажиллуулав. Нийт гарсан ажлын байрны тоо байнгын 23, улирлын болон түр ажлын байр давхардсан тоогоор 110 гарав.	100%
51	6. Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд: 7. Соёл, спортын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд:	6.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэн нийгмийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх.	Үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж байгууллагын 50-иас дээш хувь нь хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байна.	Төсөвт 6 байгууллага байгаа ба бүгд хөгжлийн бэрхшээлтэй иргэн орж гарч үйлчлүүлэхэд зориулагдсан замтай. Мөн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээг хэрхэн хүртээмжтэй хүргэж байх талаар зөвлөгөө өгч гарын авлага материал тараав.	90%
52		6.3. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллах.	Төрийн байгууллагуудад бүрэн хэрэгжүүлнэ.	Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт хороог хуралдуулан, хэлэлцээрийг холбогдох газарт хүргүүлэн бүртгүүлсэн ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	90%

1	3	4	5	6	7
53	6.4. Ахмад настнуудад мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хүндэтгэлийн болон нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх.	1.650.000	5-аас дээш арга хэмжээ зохион байгуулж нийт ахмадын 60-аас дээш хувийг оролцуулсан байна.	Ахмад настнуудын талаарх мэдээ судалгааг холбогдох газарт хугацаанд нь хэрэгжүүлсэн. Олон улсын ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх нэгдсэн хөтөлбөрийг гаргаж сумын Засаг даргаар батлуулсан. Энэ ажлын хүрээнд сумын нийт ахмадуудын судалгааг гаргаж, сумын ЗДТГ, бусад төрийн байгууллагууд, ахмадын хороо хамтран ахмадуудын дунд Софт волейбол, шатар, шагай шүүрэх, дуун цэнгүүн, баярын хурал, бүжгийн тэмцээн, хүлээн авалт цайллага зэргийг зохион байгуулсан. Мөн Эрүүл мэндийн төвийн статистикч бага эмч С.Цэнгэлмаа “Ахмад настны талаар статистик мэдээлэл” “Эрүүл, зөв амьдрах дадал хэвшил” сэдвээр мэдээлэл сургалт зохион байгуулав. Нийт 147 ахмад настан оролцсон. Үйл ажиллагаанд нийт 1650,000 төгрөг зарцуулсан.	100%
54	6.5. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд малчдыг хамруулах		Нийт малчдын 60-аас дээш хувийг сайн дурын даатгалд хамруулсан байна.	2022 онд нийт 610 малчныг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулсан.	100%
55	6.6. Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулах.		Чадавжуулах арга хэмжээ 2-оос дээш, төлөвлөгөөний биелэлтийг 80-аас дээш, кейс илрүүлэлт, шийдвэрлэлтийн хувийг 70-аас дээш хувьтай хэрэгжүүлж, ажиллагааны нэмэгдсэн байна.	Сумын ИТХ-ын 2022 оны 05 дугаар хуралдаанаар сумын Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, тус бүр жилийн ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Хамтарсан багийн гишүүдийг чадавжуулах сургалтанд 3 удаа хамрагдсан. Хагас жилийн байдлаар 12 кейс илрүүлэлт хийж, шаардлагатай нийгмийн үйлчилгээнд холбон зуучлан ажилласан. Гишүүдийн 80%-аас дээш хувь нь 5-аас дээш жил мэргэжлээрээ ажилласан туршлагатай боловсон хүчнээр хангагдсан. Хамтарсан багийн хурлыг тогтмол хийж, гишүүн тус бүрийн хуулиар хүлээсэн үүргийг хангуулах талаар анхааран ажиллаж байна. хүүхдийн тусламж мэдээллийн утсыг сурталчилснаар 108 дахь дуудлага мэдээллийн тоо нэмэгдсэн. Нийт Гэр бүл хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой 6 дуудлага мэдээлэл ирсний нөхцөл байдлыг судлан 12 тохиодол дээр кейс нээж урьдчилан сэргийлж ажиллаж байна.	100%
56	6.7. Жендэрийн дэд салбар хороог байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах		Дэд салбар хороодын гишүүдийн чадавх нэмэгдэж төлөвлөгөө 80-аас дээш хувьтай биелсэн байна.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хороог сумын ИТХ-ын 05 дугаар хуралдаанаар шинээр байгуулан ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийг 1 удаа зохион байгуулж 87 төрийн албан хаагчдийг хамруулсан. Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэхээр сумын “Нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр”-т тусган оруулсан. Ажлын байрны бэлгийн дарамтаас сэргийлэх талаарх заалтыг байгууллагуудын албан хаагчдын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлтээр оруулахаар удирдах албан тушаалтнуудад өвлөж ажилласан.	100%

1	3	4	5	6	7
57	7.1. Соёлын байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, иргэдийг соён гэгээрүүлэх	2880,0 төгрөг	Соёлын төвийн орчин нөхцөл сайжирч, үйлчлүүлэгч иргэдийн тоо нэмэгдсэн байна.	ОНХ сангийн хөрөнгө оруулалтаар соёлын төвийн ОНХ танхимд 10 сая төгрөгийн шилэн хорго 8ш, хөшиг 5ш, дорж 10м, зургийн жааз 60ш камер 2ш, үзвэрийн заланд нэмэлт гэрэлтүүлэг 4ш, зайны микрофон 1ш, гадна хаяг, гэрэлтүүлэг, өлгүүрийн болон бэлтгэлийн өрөө зэргийг 2880.0 гаруй төгрөгөөр тохижуулсан байна. Иргэдийн хандиваар зайн микрофон 1ш, бүжгийн гутал 20ш, 68ш бүжгийн дээл зэргийг авсан байна. Энэ онд 128 үйл ажиллагааг зохион байгуулж 21256 хүн хамрагдсан байна.	100%
58	7. Соёл, спортын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд:	7.2. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлэх.	Дасгал хөдөлгөөнөөр хичээллэгчдийн тоо нэмэгдсэн байна.	Цэнгээнт бүжиг, Эртэч Баянговьчууд, 108 мөргөл зэрэг арга хэмжээг насанд хүрэгчдийн дунд зохион байгуулсан бөгөөд энэ арга хэмжээнд 109 хүн хамрагдсан байна.	100%
59	8. Төсөв, төрийн сангийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх хүрээнд:	7.3. Угийн бичгийг хөтлөх, хэрэглээг нэмэгдүүлэх	Нийт өрхийн 20-оос дээш хувь нь хөтлөж хэвшсэн байна	Угийн бичиг хөтлөх сургалтыг 3 удаа зохион байгуулсан бөгөөд сургуулийн бага ангийн сурагчдын эцэг эхчүүд, төрийн албхн хаагчид, зорилтот бүлгийн өрхүүд, 8-9 ангийн сурагчид 519 хүн хамрагдсан байна. Нийт 273 өрх буюу нийт өрхийн 25% ураг удмын номоо гаргаж ургийн бичгээ хөтлөж байна	100%
60		8.1. Улсын болон орон нутгийн 2022 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг хугацаа алдалгүй тендер зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах,	Хуулийн дагуу худалдан авалт хийсэн байна Мэдээллийн ил тод байдал хангагдсан байна	2022 оны худалдан авах ажиллагаа 100% цахимаар явагдсан.	100%
61	8. Төсөв, төрийн сангийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх хүрээнд:	8.2. Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу нийтэд ил тод болгох мэдээллийг хууль, журамд заасан хугацаанд багтаан үнэн зөв мэдээлэх	Төсвийн ил тод байдал хангагдсан байна.	Шилэн дансны хуулийн дагуу сар бүрийн 08-ний дотор шилэн дансанд мэдээллээ байршуулдаг	100%
62	9. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх, хүнс, худалдаа үйлчилгээний салбарын хүрээнд:	8.3. Сум хөгжүүлэх сангийн 2011 оноос хойш хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг барагдуулах.	Сум хөгжүүлэх сан алдагдалгүй болсон байна.	2022 оны байдлаар 19 чанаргүй зээлдэгчид байснаас 5 зээлдэгч зээлээ бүрэн төлж, 14 зээлдэгчийн материалыг авилгатай тэмцэх газарт шилжүүлсэн байгаа. 2022 онд 4 шинэ зээлдэгч нэмэгдсэн. Зээлийн төлбөрийг хуваарийн дагуу төлөлт явагдаж байна.	100%
63		8.4. Олгосон санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг батлагдсан хуваарь зориулалтын дагуу зарцуулах	Төсвийн сахилга бат сайжирсан байна.	ОНХСангийн төсөл арга хэмжээний жагсаалтын дагуу санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан.	100%

1		3	4	5	6	7
64		8.5. Улс, орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр жигд ханган биелүүлж, төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх.		Төсвийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна.	Оны эхний 11 сарын байдлаар татварын нийт орлогоор 253500,0мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 292169,6мянган төгрөгийн орлогыг татвар төлөгчдөөс татан төвлөрүүлж 115 хувиар биелэж байна. Үүнээс: УТО-оор 5300,0мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 4509,4мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 85 хувиар, ОНО-оор 242,000мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 284680,1мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 117 хувиар, СТО-оор 222500мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 265439,9мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 119 хувиар тус тус биелэлттэй байна.	100%
65		8.6. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 18/14 дүгээр “Бичил худалдаа, ажил үйлчилгээний албан татварын хэмжээ” тогтоолын хэрэгжилтийг хангаж хувиараа хүн тээвэр, ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэгчлангуу болон ил задгай худалдаа үйлчилгээ эрхлэгчдээс албан татварыг төсөвт төвлөрүүлэх,		ХХОАТ-ын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна.	Аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу өөр аймгаас ирж худалдаа үйлчилгээ эрхэлсэн 8 татвар төлөгчөөс тогтоолын дагуу албан татварын ногдуулан нийт 510,0мянган төгрөгийн орлогыг сумын төсөвт төвлөрүүлсэн.	100%
66		8.7. Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг зах зээлийн бодит үнэлгээгээр шинэчлэн тогтоож, орлогыг нэмэгдүүлэх		Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг зах зээлийн бодит үнэлгээгээр шинэчлэн тогтоож дагаж мөрдсөн байна.	Үл хөдлөх албан татвар төлөгч 10 татвар төлөгчийн хөрөнгийн үнэлгээнд нийцүүлэн тогтоож, бүртгэл мэдээллийн үнэн зөв байдлыг хангаж, ҮХЭХАТ-ыг төсөвт төвлөрүүлэн ажилласан.	100%
67		8.8. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, суманд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбож, төлбөрийн баримтын олгож хэвших.		Үйл ажиллагаа эрхлэгчдийг цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбож, төлбөрийн баримтын системд олгодог болсон байна.	Татварын хэлтсийн даргын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/50 дугаар тушаал “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай”-ны дагуу үйл ажиллагаа явуулж буй 17 иргэн, хуулийн этгээдийн ажлын байранд биенчлэн очиж, нэгдсэн системд холбож, бүртгэлжүүлэн төлбөрийн баримт олголтыг нэмэгдүүлэх, иргэдэд төлбөрийн баримт олгож байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан. Нэгдсэн системд холбож, бүртгэлжүүлэн төлбөрийн баримт олголтыг нэмэгдүүлэх, иргэдэд төлбөрийн баримт олгож байгаа эсэхэд хамрагдсан 17 иргэн, хуулийн этгээдээс нэгдсэн системд холбогдож төлбөрийн баримт тогтмол олгож байгаа- 8, тогтмол бус олгож байгаа-6, нэгдсэн системд холбогдоогүй-3/шинээр үйл ажиллагаа эхэлсэн/ хамрагдлаа. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар нэгдсэн системд холбогдоогүй 3 татвар төлөгчдөд шаардлага бичиж, хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар сургалт мэдээллээр өгч ажилласан.	100%

1	3	4	5	6	7
68	8.9. Аймгийн Засаг дарга, газрын албанаас олгосон газар эзэмших, ашиглах эрх, тэдгээрийн нэгж, талбаруудын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж орлогыг нэмэгдүүлэх.		Цахимжуулалтыг бүрэн хийж, орлогын төлөвлөгөөг давуулсан биелүүлсэн байна.	Сумын 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар өмчлөх, эзэмших эрхийн нийт 13 нэгж талбарыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн, өмнөх онуудад ашиглах эрх олгогдсон 1 нэгж талбарын төлбөрийн ногдолыг хийж татварын удирдлагын ерөнхий систем рүү илгээгдсэн.	100%
69	8.10. Тухайн сумд бүртгэлтэй ААН, байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд e-balance.mof.gov.mn цахим хуудсаар тайлагнасан байх.		Тайлангийн ирц 85 хувьд хүрч, өмнөх оноос 10 хувь нэмэгдсэн байна.	Эхний 3 улиралын байдлаар төсвийн 9, ААН 10 байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тайлганасан.	90%
70	8.11. Байгууллагуудын үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж, дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулах.		Байгууллагын эрсдэлийн түвшинг бууруулсан байна.	Байгууллагуудын үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж, дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллаж байна.	100%
71	8.12. Хяналт шалгалт, дотоод аудитаар өгсөн зөвлөмж түүний хэрэгжилтийг хангах.		Зөрчил бүрэн арилсан байна.	2021 оны шилэн дансны тайланд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг албан бичгээр нотлох баримтын хамт хүргүүлсэн.	100%
72	8.13. Худалдан авах ажиллагааны тайланг хуулийн хугацаанд tender.gov.mn цахим системд байршуулж, тайлагнах.	Орон нутгийн хөрөнгийн сан тендер зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 245000 төгрөг, тухайн ажлуудыг хийж гүйцэтгэхэд 598850.8 мянган төгрөгний санхүүжилт олгосон.	Худалдан авах ажиллагааг ил тод, шуурхай зохион байгуулж, мэдээлсэн байна.	2022 оны худалдан авах ажиллагааны тайланд тендер зарлах 9 бараа, ажил, үйлчилгээ төлөвлөгдсөн. Төлөвлөгөөт тендэр бүгд зарлагдаж, шалгарсан аж ахуй нэгжээр ажлыг гүйцэтгүүлсэн. Худалдан авах ажиллагааны тайланг хуулийн хугацаанд tender.gov.mn цахим системд байршуулсан. Хавсралт : 1 файл	100%
73	8.14. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэх, хяналт тавих.		Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт хийгдэж, мэдээлэл нь бодиттой болсон байна.	жилийн эцсийн мал, хүн ам, тэжээвэр амьтадын тооллогоор хүн ам өрхийн мэдээллийн сангийн мэдээлэл бүрэн шинэчлэгдсэн.	100%
74	9.1. Сумын аюулгүй нөөцийн өвс тэжээлийг зохих түвшинд бэлтгэх.		Сумын өвс, тэжээлийн нөөцийг зохих түвшинд бэлтгэн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 85-аас дээш хувиар хангасан байна.	Баянговь сумын нөөцөд 20тонн хивэг тэжээл, 30тонн өвс, Цагаан ямаат хоршоо 20тонн өвс бэлтгээд байна.	100%

1	2	3	4	5	6	7
75	9. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх, хүнс, худалдаа	9.2. Малын шилжилт хөдөлгөөн болон малын гаралтай бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах.		Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж эрсдэлийг бууруулсан байна.	Малын халдварт, гоц халдварт өвчнөөс сэргийлж хяналт тавин ажилласан.	90%
76	үйлчилгээний салбарын хүрээнд: 10. Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд:	9.3. Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, үйл ажиллагаанд хяналт хавих		Хоршоодыг чадавхжуулж, хөнгөлөлттэй зээлийн журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Хоршоог хөгжүүлэх сангаас олгох зээлийг журамын дагуу олгож байнгын хяналт тавиж ажиллаж байна.	100%
77		9.4. Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тариалалт ургац хураалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.		Хавсралтаар өгөгдсөн тариалалт ургац хураалтын төлөвлөгөөг бүрэн хангасан байна.	Тариалалтын талбайг бүрэн ашигллаж ургацыг нэмэгдүүлэх тал дээр анхаарж ажилласан.	100%
78		9.5. Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.		Малын халдварт, гоц халдварт өвчин гараагүй байна.	Баянговь сумд отор нүүдэлээр ирсэн малыг ариутгал халдваргүүжилт хийж, хяналт тавин ажилласан.	100%
79		10.1. “Тэрбум мод” тарих ажлын хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.	19650,0	Шинээр 25.0 мянган мод тарьсан байна ургалт 70-аас дээш хувьтай байна.	Тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилон хавар, намар 2 удаа зохион байгуулан, 4 төрлийн 5560 мод сөөгийг тариалсан хашаандаа тариалсан модны тоо 850, мод тарьсан өрхийн тоо 105, цэцэрлэгт хүрээлэнд тарьсан модны тоо 4177, албан байгууллагуудын тарьсан мод 323, хамгаалалтын зурвсад тарьсан мод 210 тус тус тариалсан.	100%
80	10. Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд:	10.2. Булгийн эхийг хашиж хамгаалах тохижуулах ажлыг зохион байгуулах.	700,000	Гол мөрний урсац нэмэгдсэн байна.	Гурван булаг, Хэлтгийн булгийн эхийн хайс хамгаалалтыг засварийг хийсэн. Хавсралт : 3 зураг	100%
81	11. Хөрөнгө оруулалтын чиглэлийн хүрээнд:	10.3. Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн бодлого төлөвлөлтийг сайжруулах.		Иргэдийн эрүүл, амьдрах орчин сайжирсан байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цагаан голын услалтын систем хийгдсэн. Цагаан тохойн тариалангийн газарт малын тэжээлийн ургамал тариалах зориулалтаар гүн өрмийн худаг гаргах ажил хийгдэж эхэлсэн.	90%

1	3	4	5	6	7
82	10.4. Нүхэн жорлонгийн тоог багасгаж, хөрсний бохирдлыг бууруулах.		Нүхэн жорлонгийн тоог бууруулсан байна.	Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Цэцэрлэг, Соёлын төв, Цагдаа нийтийн бие засах газруудыг тохижуулан сайжруулах, засварлах ажлууд хийгдсэн. Мөн айл өрхүүдийг нийтийн шугам сүлжээнд холбох ажил хийгдэж байна. Нийтийн шугам сүлжээнд холбогдсоноор агаарын бохирдол багсаж, стандартын шаардлага хангахгүй нойлын тоо цөөрөх, гадна орчны хог хаягдал байхгүй болно. Сумын унд ахуй усан хамгамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа худгийн эрүүл ахуйн хориглолтын ба эрүүл ахуйн хязгаарлалтын бүсэд багтаж байгаа нүхэн жорлонгийн судалгааг хийлээ. Сумын 3 гүн өрмийн худгийн хориглолт, хязгаарлалтын зурваст албан байгууллага, айл өрхийн 44 энгийн нүхэн жорлон байна. Үүнээс эрүүл ахуйн хориглолтын бүсэд 15, хязгаарлалтын бүсэд 29 байна. 7 албан газар нийтийн цэвэр бохир усны системд холбогдсоноор ариун цэврийн байгууламжийн тоо нэмэгдсэн.	100%
83	10.5. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуулийн дагуу зарцуулах, хяналтыг сайжруулах.		Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах нөхцөлс бүрдсэн байна.	Байгалийн нөөцийн хууль бус ашиглалт дээр хяналт шалгалтыг сар бүр хийж иргэдэд зөвлөгөө зөвлөмж өгч ажилласнаар хууль бус байгалийн эсрэг гэмт хэрэг зөрчил гараагүй, байгалийн нөөц ашиглалтын орлого байхгүй хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
84	10.6. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, тогтолцоог нэвтрүүлэх.		Иргэдийн цэвэр эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	Хог хаягдлын менежментийг сайжруулах үүднээс сумын төвийн их цэвэрлэгээг улирал бүр, авто зам, усан сан бүхий газар түүний хамгаалалтын бүс орчмын хог хаягдлын цэвэрлэгээг хавар, намрын улиралд зохион байгуулж хэвшээд байна. Хог хаягдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, “Ус үндэсний хөтөлбөрийн” 3.6.11 дэх заалтын хүрээнд Нийтийн цэвэрлэгээг 3 удаа, зохион байгуулан нийт 300 га талбайн 50 т/н хог хаягдлыг цэвэрлэсэн. Хог хаягдлыг цэвэрлэх ажилд давхардсан тоогоор төрийн 6 байгууллага, төрийн бус 2 байгууллагын 125 албан хаагч, 140 гаруй иргэд, сургуулийн 6-9-р ангийн нийт 320 гаруй хүүхэд идэвхтэй оролцсон. “Дэлхийн байгаль хамгаалах” өдрийг угтаж, усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах зорилгоор усан сан бүхий газар түүний хамгаалалтын бүс орчмын хог хаягдлын цэвэрлэгээг 1 удаа мөн Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны 8 сарын 31-ний өдрийн 9 дүгээр сарын албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж Сумын Засаг даргын Захирамж, төлөвлөгөө батлуулан түүний дагуу 09 дүгээр сарын 08-ны өдөр Цагаан гол, Гурван булаг, Хэлтгий булаг, Нууцат, Цагаан эргийн рашааны хамгаалалтын бүс орчмын хог хаягдлыг бүрэн цэвэрлэх арга хэмжээг авч ажиллаа. нийт 19 га талбайн 7 т/н хог хаягдлыг цэвэрлэв. Хог хаягдлыг цэвэрлэх ажилд төрийн 6 байгууллагын 75 албан хаагч, сургуулийн 8-9-р ангийн нийт 125 гаруй хүүхэд идэвхтэй оролцсон.	100%
85	10.7. Стандартад нийцсэн хогийн савыг байршуулах		10-аас доошгүй хогийн сав байршуулсан байна.	Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын хогийн савыг сайжруулах талаар зөвлөмж өгч Эрүүл мэндийн төв, Сургууль, Цэцэрлэг, Засаг даргын Тамгын газар, ангилан ялгалт хийх хогийн савыг байгуулалгын орчинд байршуулсан	100%

1	3	4	5	6	7	
86	10.8. Бичил уурхайн эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих		Байгаль орчныг хамгаалсан байна.	Тус сумд бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч байхгүй.	100%	
87	10.9. Ашигт малтмал, газрын тосны уламжлалт болон уламжлалт бус эх үүсвэрийн эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хяналт тавих		Байгалийн баялгийг зүй зохистой ашигласан байна.	Эрэл хайгуулын үйл ажиллагаа хийгдээгүй болно.	100%	
88	11.1. Улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний саналыг хууль журмын дагуу боловсруулан иргэд, олон нийтийн саналыг авч, эрэмбэлэн холбогдох хэлтэст ирүүлэх.		2023 онд Улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, журмын дагуу боловсруулан иргэд, олон нийтийн саналыг авч, эрэмбэлэн холбогдох хэлтэст ирүүлсэн байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний саналыг хууль журмын дагуу боловсруулан иргэд, олон нийтийн саналыг авч, эрэмбэлэн холбогдох хэлтэст хүргүүлсэн. Санал өгсөн тоо- 444 Хавсралт : 1 файл	100%	
89	12. Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд:	12.1. Батлан хамгаалах үйл ажиллагаа, бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг хангах.	нийт гурван сая төгрөг	Орон нутагт батлан хамгаалах үйл ажиллагаа, тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, аж ахуйн нэгж, бүртгэлээр цэргийн 18-50 насны бүх эрчүүдийн эрүүл мэндийн иргэдэд сурталчилснаар үзлэгт хамруулж сургалт гарын авлагаар ханган шагай иргэдийн цэргийн үүргийн харвааны баг, цуваа, бөхийн барилдаан, тэмээний уралдаан зохион байгуулж, Засаг даргын тамгын газрын эрчүүд Эх орон минь эрчүүдээр дутна концерт тоглож батлан хамгаалах хуулийг ёуртёилан ажилласан. Мөн 1,2 р ээлжийн цэрэг татлагыг амжилттай зохион байгуулж 18-26 насны бүх эрчүүдийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, эхон% зүрхний цахилгаан бичлэг хийсэн.	100%	
90	12. Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд:	12.2. Цэргийн бүртгэлийг зохион байгуулан явуулах, мэдээ, судалгаа, тайланг ирүүлэх.	хоёр сая таван зуун мянга	Цэргийн бүртгэл судалгааны нэгдсэн тогтолцооны чанар дээшилсэн байна.	2021 оны цэргийн бүртгэлийг хуулийн хугацаанд 1-р сард зохион байгуулж 30 төрлийн тайлан судалгааг хугацаанд нв гаргаж хүлээлгэн өгсөн хамрагдалт 100 хувь байсан	100%
91	хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд:	12.3. Цэрэг татлагын ажлыг зохион байгуулж хяналтын тоог биелүүлэх.	нэг сая төгрөг	Цэрэг татлагын хяналтын тоо биелэгдэнэ.	2022 онд манай сумд аймгийн Засаг даргын Захирамжийн дагуу 1,2-р ээлжийн цэрэг татлага амжллттай зохион байгуулж цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт 2 удаа хамруулж хяналтын тоог 100 хувь биелүүлж ажилласан.	100%
92	хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд:	12.4. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг сум, орон нутгийн бүтээн байгуулалтад оролцуулах.	тэг	Орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцох оролцоо сайжирна.	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг сум, орон нутгийн бүтээн байгуулалтад оролцуулж 80 жилийн ойн ажил, цагаан голын гүүрний ажил, хуучин эрүүл мэндийн төвийн барилгаа нураах ажилд оролцсон. мөн аймгаас зохион байгуулсан ажилд 2 удаа 100 оролцсон Баянбулаг сумд 1 удаа оролцсон.	100%

1		3	4	5	6	7
93	12. Батланг хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд:	12.5. Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр төлөх иргэдийн төлбөрийг төрийн санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах.	0	Мөнгөн төлбөрийн орлого нэмэгдэнэ.	Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр төлөх иргэдийн төлбөрийг төрийн санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж 5 иргэн хамрагдахаас 1 иргэн бүрэн чөлөөлөгдөж, 2 иргэн 100% төлсө., 2 иргэнд төлөх мэдэгдлийг хүргүүлэн ажиллсан.	90%

ХЯНАСАН
ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

НЭГТГЭСЭН
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.БАТЖАРГАЛ